

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ШИНЭ НОМЛОЛЫН ҮНДЭС

П. Очирбат*

I. Монгол улсын гадаад эдийн засгийн харилцаа - үндэсний эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг мөн

Социализмын үед Монголын эдийн засагт Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ), Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн (ЭЗХТЗ) орнуудын зээл тусламж дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 30 гаруй хувийг бүрдүүлдэг байлаа.

1990-ээд оны эхээр ЗХУ, ЭЗХТЗ задарч манай эдийн засгийг тэтгэж байсан гадаад эх үүсвэр алга болох үед Монгол улсын хувьд эдийн засгийн сүйрэл нүүрлэж, хөрөнгө оруулах бүү хэл тухайн цагийн хэрэгцээгээ хангах төлбөрийн чадваргүй байдалд орсон билээ. Энэ бол гадаад эдийн засгийн харилцаа (ГЭЗХ)-ны нэг туйлтай загвар туйлын хэврэг болохыг үзүүлсэн том сургамж байлаа.

Буй болсон нөхцөл байдлаас гарах арга замыг шуурхай эрэлхийлсний дүнд Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банк (ДБ), Азийн хөгжлийн банк (АХБ) зэрэг дэлхийн валют-санхүүгийн байгууллагад элсэж, хандивлагч орнуудын төлөөлөл бүхий олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс шуурхай тусламж авч хямралыг харьцангуй богино хугацаанд хохирол багатай давж эдийн засгийн уналтыг зогсоож чадсан юм. Энэ нь нэг талаас Монгол улсын хөдөлмөрийн хуваарьт орж чадаагүй ГЭЗХ-ны эмзэг байдлыг харуулж байгаа боловч нөгөө талаар ГЭЗХ-г нээлттэй, олон туйлтай болгож чадвал дэлхийн ГЭЗХ-ны системд өөрийн тодорхой орон зайг эзлэх боломжтойг нотлон харуулсан бодит баримт юм.

1991 оноос хойш өнгөрсөн 16 жилийн хугацаанд эдийн засгаа либералчлан зах зээлийн харилцаанд шилжүүлэх, эдийн засаг, эрх зүйн шинэтгэлийг амжилттай хийсний

* Монгол улсын анхны Ерөнхийлөгч, ШУТИС-ийн УУИС-ийн Уурхайн менежмент, тогтвортой хөгжлийн профессорын багийн тэргүүлэх проф., доктор

үр дүнд хувийн болон төрийн өмчийн, холимог хэлбэрийн хэвшлүүд тогтож ДНБ-ний 80 орчим хувийг хувийн хэвшлийн хүрээнд үйлдвэрлэдэг болж байна. Ингэснээр ГЭЗХ-нд оролцох боломж хүрээ өргөсөж байна. Өнөөгийн байдлаар Монгол улсын ГЭЗХ-нд гурван үндсэн хэлбэр зонхилж байна.

1. Хөгжлийн албан ёсны туслалцаа (ХАЁТ)
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)
3. Гадаад худалдаа (ГХ)

1. ХАЁТ-ны хөрөнгийн ихэнхийг түлш, эрчим хүчний болон дэд бүтцийн салбарын үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, сэлбэг хэрэгслээр хангах, техник технологийг боловсронгуй болгох, үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангахад зориулан ашигласан байна. ХАЁТ-ны хөрөнгийн бүтцийн 47,6% зээл, 52,4% буцалтгүй тусламж байжээ. Энэхүү тусламж хэдийгээр хөгжлийн гэдэг нэртэй боловч ХАЁТ-ны хөрөнгө нь шинэ хүчин чадал буй болгож, хөгжлийн өсөлтөд нөлөөлөх, хөрөнгө оруулалтын эх үүсвэр болж чадаагүй эргээд ГЭЗХ-д оролцох бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ болж хувирч чадахгүй байна. Монгол улс зээл тусламжаас хараат байдлаараа дэлхийд тавдугаарт ордог атлаа эдийн засгийн хөгжлийн түвшингөөрөө дэлхийд 150 дугаар байранд байна. Цаашдаа ХАЁТ-ны хөрөнгийг түр зуурын тулгамдсан цаг үеийн арга хэмжээнд зарцуулах, үр ашиг багатай олон янзын төсөл боловсруулах, улсын төсвийн алдагдлыг гадаадын хөрөнгийн урсгалаар нөхдөгийг болиулж, эдийн засгийн өсөлтийг хангах хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгох тодорхой чиглэл, зорилготой ашиглах хэрэгтэй юм.

а) Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) бол хөрөнгө, технологи, мэдлэг, зах зээл, хамтдаа орж ирдэг ГЭЗХ-ны хамгийн дэвшилттэй хэлбэрийн нэг юм. Монгол улсын ГШХО-ын 2006 оны байдлаар 17% БНХАУ, 12.4% Канад, 7.3% БНСУ, 4.9% Япон, 3.5% АНУ, 3.2% ОХУ, харин Их Британи, Виржины арлууд нийлээд 5.8%-ийг оруулсан байна (ГХОХГАгентлагийн мэдээ). 1990-2006 онд ГШХО нь үйлдвэрлэл үйлчилгээний хүрээг өргөжүүлж, ажлын байр, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж, хөгжлийг түргэтгэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой хэлбэр юм. ГШХО-ын нөхцөл нь өрсөлдөх чадвар бүхий эрх зүй, татварын тогтвортой байдал хангагдсан байх ёстой. Улс төр, нийгмийн тогтвортой байдал эрсдлээс хамгаалах таатай нөхцөл зэргийг

харгалзан харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан хамтын ажиллагааны хэлбэр юм. Эдгээр нөхцлийг бүрдүүлэхгүй бол ГШХО орж ирэх боломж хязгаарлагдах болно.

б) Гадаад худалдаа (ГХ) нь ГЭЗХ-ны нийтлэг бөгөөд хязгаарлагдмал хэлбэр юм. Бараа үйлчилгээний нэр төрөл, эрэлт, өрсөлдөх чадвараас ГЭЗХ-нд ГХ-ны эзлэх байр суурь тодорхойлогдоно. ГХ-ны тэнцэл түүнээс хамаарна. Манай экспорт цөөн нэрийн түүхий эд, хагас боловсруулагдсан бүтээгдэхүүнээс бүрддэг хэвээр. Өнөөгийн байдлаар Монголын гадаад худалдаа, эдийн засгийн өсөлтийг хангахад жинтэй хувь нэмэр оруулах эх үүсвэр болж чадаагүй байна. Монгол улсын ГЭЗХ-ны өнөөгийн байдал эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, эзэлж буй байр суурь нь социализмын үеийн “хангамж - борлуулалт” загвараа хадгалсан дэлхийн зах зээлд орж чадаагүй хэвээр байна. Энэ байдал удаан үргэлжилбэл дэлхийн хөгжлөөс хоцрон “бооцоот-орны” эгнээнд үлдэж мэдэх юм.

II. Дэлхийн эдийн засгийн шинэ парадигма

Дэлхийн эдийн засаг XX зууны аж үйлдвэрийн загвараас XXI зууны тогтвортой хөгжлийн загварт шилжиж байна. XX зууны хөгжлийг нэг талаар шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжлийн зуун гэх боловч нөгөө талаар байгалийн нөөцийг хайр гамгүй цөлмөсөн, хүн төрөлхтнийг туйлдуулсан техногений зуун байлаа гэж дүгнэдэг. Мэдээж хэрэг хүн төрөлхтөн өөртөө халтай хөгжлийн ийм загвараас аль болох түргэн салахыг эрмэлзэх нь зүйн хэрэг. Дэлхийн хөгжлийн шинэ загварын цөм нь агуулгын хувьд сонгодог эдийн засгаас тэс өөр “шинэ эдийн засгийн загвар” юм. Энэ загвар бидэнд өртгийн хууль, ашгийн тухай ойлголт болон дэлхийн зах зээл, дэлхийн үнэ, үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашиг зэрэг эдийн засгийн категориудад шинээр хандах боломжийг өгч байна. Тухайлбал өртгийн хууль шинэ эдийн засгийн шинжийн нөлөөллийн дор гео эдийн засгийн орон зайд угсаатны эдийн засгийг үндэстэн дамжсан өртөг болгон хувиргах гүнзгий өөрчлөлтөд орж байна. Дэлхийн зах зээл гэхэд л дэлхийн нөхөн үйлдвэрлэлийн процессыг л илэрхийлэх жишээтэй.

Интернационалжсан нөхөн үйлдвэрлэлийн цөмд (ИНЦ) үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь түүнийг бүтээсэн үйлдвэрлэл-хөрөнгийн сүлжээний хүрээнд борлогдох жинхэнэ бараа болно. Энэ хүрээг дэлхийн зах зээл гэх бөгөөд энд дэлхийн зах зээлийн үнээр дамжиж дэлхийн орлого бүрэлдэнэ. Өөрөөр хэлбэл дэлхийн орлого, дэлхийн зах зээлийг бүрдүүлэгч дэлхийн хөдөлмөр – үйлдвэрлэл - хөрөнгө - экологийн

интернационалжсан сүлжээ юм. Энэ сүлжээтэй холбогдохгүйгээр гадаад эдийн засгийн харилцааг үр ашигтай хөгжүүлэх боломж хязгаарлагдмал байх юм. Шинэ эдийн засгийн энэхүү загвараас *дэлхийн орлого* гэдэг ойлголт, түүнээс хүртэх боломжийн талаар зарим зүйлийг тодруулъя. Дэлхийн орлого гэж улс орнуудын эдийн засгийн харилцааны үйл ажиллагааны орлогын дэлхийн хэмжүүр юм байна. Энэхүү орлогыг үндэстэн дамжсан эдийн засгийн бүтцийг бүрдүүлэгч орнуудын болон уг *бүтцэд ороогүй ч гэсэн* үндэсний баялгийн төрлөөсөө оролцуулсан улс дундын нөхөн үйлдвэрлэлийн хүрээн дэх бараа, үйлчилгээний борлуулалтаас олно. Ингэж олсон орлогыг интернационалжсан нөхөн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зориулна. Дэлхийн орлогоос хүртэхийн тулд дэлхийн нөхөн үйлдвэрлэлийн сүлжээнд оролцох хэрэгтэй юм байна. Ингэж байж зээлийн дарамтаас зайлж дэлхийн орлогоос хуваалцах эрхийг олох юм байна. Дэлхийн эдийн засгийн гадаад харилцааны парадигма ийм байна.

III. Геоэдийн засгийн орон зайд өөрийн байр суурийг олох боломж

Бид геополитик, геостратеги гэдэг үгүүдийг ихэвчлэн орчуулгагүй хэрэглээд заншчихсан. Түүнтэй адил геоэкономика, геоэкономическое пространство гэсэн орос хэллэг ойлголтыг “геоэдийн засаг”, “геоэдийн засгийн орон зай” гэж хэлбэл ямар вэ? Геоэдийн засаг гэдэг ойлголтод “дэлхийн орлогыг” бүрдүүлэх болон хуваарилах үйл ажиллагаа явуулах орон зайд өөрийн гэсэн орон зайг цаг алдалгүй олж авахын тулд хүч бодлогоо зөв хуваарилах арга ухааныг багтааж болмоор байна. Улс орон бүр хөгжлийнхөө ирээдүйд санаа тавьж хэтийн төлөвийнхөө стратегийг төсөөлж хөгжлийнхөө цогц бодлого, номлол, стратегийг боловсруулж байна. Үндэсний цогц хөгжлийн үндсэн суурь түүнийг хэрэгжүүлэх стратегийн хэрэгслийг сонгохдоо дэлхий дахины өнөөгийн нөхцөлтэй уялдуулан харгалзах хэд хэдэн зарчмын баримжаа байна.

а) Бүхнийг багтаасан даяаршлын үйл явц гадаад дотоод үйл ажиллагааны болон гадаад дотоод улс төрийн бодлогын заагийг их бүдэгрүүлж байна. Дэлхийн эдийн засаг, санхүү, үйлдвэрлэл, нийгэм, улс төрийн болон бусад бүх хүрээнд гарч буй үйл явц даяаршиж буй түүний урсгал нь аль ч улс үндэстний эдийн засгийн хөгжлийн баримжаа болж байна. Энэ байдлыг үл тоомсорловоос үндэсний хөгжлийн стратегийг боловсруулах хүчин чармайлт үр дүнгүй болох магадлал ихтэй байна.

б) Улс төрийг эдийн засагжуулах үйл явц их хүчтэй болж байна. Энэ үйл явц 4 чиглэлээр явагдаж байна.

- Улс төрийн асуудлыг эдийн засгийн аргаар шийдвэрлэх;
- Стратегийн хөгжлийн улс төр, үзэл суртлын болон бусад чиглэлийг эдийн засаг руу шилжүүлэх;
- Гадаад орчинд геоэдийн засгийн сонирхлыг геополитикийн ба геостратегийн сонирхлын дээр тавих;
- Дипломат албаны сэтгэлгээг эдийн засагжуулах (М.Дүгэрсүрэн сайд энэ бодлогыг их дэмждэг хүн байсан).

Дээр дурьдаснаас үзэхэд геоэдийн засгийн энэхүү загвар нь XXI зууны дэлхийн хөгжлийн үндсэн парадигма болох төлөвтэй байна.

в) Үндэсний аж ахуйнууд алсдаа үйл ажиллагаа явуулах орчныхоо байдлыг тухайлбал геоэдийн засгийн орон зайн тухай болон түүний хэтийн хөгжлийн төлөвийн талаар сайн мэдэх явдал их чухал. Дэлхийн аж ахуйн системийн үндсэн бүрэлдэхүүн, түүний гол шинж төрхийг нарийн тооцож мэдэх явдал үндэсний эдийн засгийн гадаад харилцааны үндсийг зөв тавьж хэрэгжүүлэхэд их тус дөхөм болно.

г) Үндэсний эдийн засгийн хувьсах чадварын зүй тогтлыг зөв тодорхойлох нь түүнийг дэлхийн аж ахуйн системтэй эдийн засгийн харилцан уялдаа бүхий нэгдмэл системд өөрсдийн орон зайг зөв олоход чухал нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл үндэсний эдийн засгийг гадаад ертөнцтэй холбох загварыг зөв сонгоход онцгой анхаарах хэрэгтэй байна. Дээр хэлсэн гол зарчмуудад тулгуурлан геоэдийн засгийн мөн чанарыг тодорхойлж болох юм. Геоэдийн засаг гэдэг бол нэг талаас гадаад эдийн засгийн стратеги ба номлолыг томъёолох үзэл баримтлал, нөгөө талаас бие биенээ нөхцөлдүүлсэн харилцан хамаарал бүхий гурван хэсгээс бүрдсэн орон зайн нэгдлийг хэлж байна. Үүний нэг дэх нь дэлхийн аж ахуйн систем ба эдийн засгийн дотоод боломж, хоёр дахь нь гадаад эдийн засгийн макрозагвар ба үндэсний эдийн засгийн гадаад орчинтой холбогдох системийн үүсэл, гурав дахь нь үндэсний номлолыг хэрэгжүүлэх стратегийн хэрэгсэл юм.

Геоэдийн засгийн орон зайн хэмжүүр нь шинэ эдийн засаг “неоэкономика” гэсэн ойлголт гарч ирж байна. Шинэ эдийн засгийн загвар нь аж үйлдвэржүүлэлтийн загварын хойноос залган гарч ирж буй шинэ үе. Шинэ эдийн засаг нь даяаршлагдсан системийн иргэншлийн олон шинэ үнэт зүйлийг агуулсан загвар юм. Шинэ эдийн засаг нь амьдралын чанарыг дээшлүүлэх нөхөн үйлдвэрлэлийн төлөө техноген болон урьд өмнө

системийн гадна байсан хүчин зүйлүүдтэй зэрэгцэн орших загвар юм (үндэс угсааны, соёл иргэншлийн, ёс суртахууны зэрэг). Шинэ эдийн засгийн энэхүү шинэ агуулга, логик нь өртгийн хуулийн үйлчилгээний хүрээнд тусгагддаггүй байсан үндэс угсааны, сэтгэл зүйн, ёс суртахууны, оюун санааны зэрэг олон хүчин зүйлийг оролцуулан тооцохыг чухалд үзэж байна. Энэ бүхнээс үзэхэд эдийн засгийн урамшил, ашиг зэрэг үзүүлэлтүүд олонхи тохиолдолд яагаад шийдвэрлэх ач холбогдолтой байж чадахгүй байна вэ? Яагаад даяаршлагдсан эдийн засагт шинэ эдийн засгийн хандлагад *“стратегийн үр ашиг”* гэсэн шинэ категори илүү анхаарал татах болов гэдэг нь ойлгомжтой болж байна. Стратегийн үр ашиг гэдэг категори нь ашгаас илүү дээд зэрэглэлийн үзүүлэлт юм байна. Чухамхүү стратегийн үр ашгийн энэхүү систем нь интернационалжсан зардлыг хойшид зөв тусгах, өртгийн хуулийн үйлчилгээг зөв болгох үндсийг тавьж өгөх юм. Стратегийн үр ашиг гэдэг бол дэлхийн орлого руу нэвтэрч орох, стратегийн тэнцвэрийг олох, интернационалжсан нөхөн үйлдвэрлэлийн сүлжээг үүсгэх зэрэг геоэдийн засгийн технологийг ашиглан дэлхийн геоэдийн засгийн зураг дээр идэвхтэй ажилласнаар олох үр дүн юм. Энэ ойлголт бол геоэдийн засгийг даган гарч ирсэн эдийн засгийн үр ашгийн шинэ ухагдахуун гэдгийг анхаарч ийм үр ашгийн төлөө ажиллах хэрэгтэй байна. Бид геоэдийн засгийн бодлогыг ашиглан даяаршсан дэлхийн эдийн засгийн орон зайн хязгаарын гадна үлдсэн үндэснийхээ эдийн засаг, үндэсний болон үндэстэн дундын, түүнчлэн улсын бүтцүүдийг дэлхийн орлогын систем руу оруулахын төлөө ашиглах хэрэгтэй байна. Төрийн бодлогыг үндэснийхээ эдийн засгийн боломж, дэлхийн геоэдийн засгийн газрын зураг дээрх хувьсал өөрчлөлттэй уялдуулах шаардлагатай байна.

IV. Монгол улсын гадаад эдийн засгийн харилцааны загвар

Орчин үед гадаад эдийн засгийн харилцааны үндсэн гурван загвар байна. *Нэг нь худалдааны, хоёр дахь нь хангалт борлуулалтын, гурав дахь нь* нөхөн үйлдвэрлэлийн буюу үйлдвэр-хөрөнгө оруулалтын загвар юм. Гурав дахь загварын нэрийг олон янзаар хэлж байгаа. Тухайлбал дээрх хоёр нэрнээс гадна геоэдийн засгийн загвар, шинэ эдийн засгийн загвар гэх зэрэг 4-5 янзаар нэрлэж бичиж байна. Олон янзаар нэрлэж байвч гол агуулга нь дэлхийн орлогыг үйлдвэрлэх, түгээх геоэдийн засгийн орон зайд улс орон бүр оролцоход байгаа юм. Харамсалтай нь хөгжиж байгаа орнууд тэр дотор Монгол улс энэ боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Монгол улсын гадаад эдийн засгийн

харилцааны загвар нь социализмын үед байсан хангамж-борлуулалтын загвар хэвээр байсаар байна. Монголын гадаад эдийн засгийн харилцааны хүрээ бүс нутгийн болон дэлхийн нөхөн үйлдвэрлэлийн хүрээнд орж чадаагүй тусгаарлагдсан хэвээр байна. Манай экспортын бүтээгдэхүүн ихэвчлэн дэлхийн стандартын түвшингөөс доогуур, өрсөлдөх чадвар муутай техник технологиор үйлдвэрлэгдсэн түүхий эдийн болон хагас боловсрогдсон бүтээгдэхүүн байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь гол төлөв зээлийн хөрөнгө байна. Өндөр хүүтэй зээл нь хуримтлал үүсгэж чадахгүй өрөнд орж улмаар энэ нь хөгжлийн эх сурвалж болохоосоо ядуурлын эх сурвалж болох нь илүү байна. Гадаад эдийн засгийн харилцааны энэхүү гажуудалтай загварыг өөрчилж дэлхийн орлого бүрдүүлэх ба хуваарилах боломж бүхий үйлдвэрлэл хөрөнгө оруулалтын буюу нөхөн үйлдвэрлэлийн загварт шилжих хэрэгтэй байна. Уг загварын хамгийн энгийн хэлбэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах эсвэл гадаадад шууд хөрөнгө оруулах замаар хөрөнгө - технологи – менежмент – маркетинг - мэдлэгийн үндэстэн дамжсан цогцолбор үүсгэх явдал юм. Ингэж байж Монгол өрийн зээлнээс салж дэлхийн орлого бүтээхэд оролцож түүний хуваарилалтаас зээлээр биш авлагаар хүртэж нөхөн үйлдвэрлэлийн хөрөнгөтэй болж эдийн засгийн өсөлтийг хангах боломжтой болно. Эхлэх цэг нь дэлхийн үндэстэн дамжсан корпорацуудыг эрдэс баялгийн салбарт татан оруулах замаар дэлхийн орлогын үйлдвэрлэлд хамтран ашиглах явдал юм. Ингэснээр үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлж бүс нутгийн болон олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох өргөн боломж нээгдэнэ. Экспорт импортын бүтэц сайжирна. Бараа үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжирна. Эрсдэл багасна. Ажлын байр, орлогын эх үүсвэр нэмэгдэнэ. Үйлдвэр үйлчилгээний бусад салбарыг хөгжүүлэх хуримтлал нэмэгдэнэ. Ард түмний амьдралын чанар дээшилнэ. Өнөөдөр бид гадаад зах зээлд эрчим хүчний болон уул уурхайн түүхий эдийг хагас боловсруулсан бүтээгдэхүүний хэлбэрээр дэлхийн зах зээлийн үнээр биш ханган нийлүүлэх үнээр борлуулж байна. Энэ юуг харуулж байна вэ гэвэл Монгол улсын гадаад эдийн засгийн харилцааны бодлого дэлхийн интернационалжсан нөхөн үйлдвэрлэлийн бүтцэд ороогүй түүний гадна байгаа учраас дэлхийн зах зээлд орж чадаагүй зөвхөн гадаад зах зээл рүү хагас дутуу хөл тавьж эхэлж байгаа төдий байна. Дэлхийн нөхөн үйлдвэрлэлийн цөмд ордоггүй учраас дэлхийн орлогын хуваарилалтад хамаардаггүй, дэлхийн санхүүгийн байгууллагын зээлийг төлбөрийн хэрэгсэл гэж үздэггүй зөвхөн зээлийн хэрэгсэл гэж үздэг, ингэж авсан зээл нь өрийн дарамт болж хөгжлийг сааруулдаг. Шинэ эдийн засгийн загварын нөхцөлд

иймэрхүү байдлыг үргэлжлүүлбэл орчин үеийн дэлхийн хандлагаас хоцорч (бооцоот орон гээч болж) үлдэхнээ.

Гадаад эдийн засгийн макрозагвар

Аль ч улсын үндэсний эдийн засагт гадаад ертөнц рүү хардаг өөрийн цонх, систем бий. Тэр системд үндэсний эрх ашиг, тэргүүлэх чиглэл, гадаад эдийн засгийн харилцааны институт зэрэг багтдаг. Орчин үеийн дэлхийн эдийн засагт үндэсний эдийн засгийн эзлэх тогтвортой байр суурь нь дараах стратегийн гурван үзүүлэлтийн харилцан уялдаагаар тодорхойлогдох болж байна.

1. Гадаад ертөнцөд буй болсон нөхцөл байдал
2. Үндэсний эдийн засгийн байдал
3. Гадагшаа харах цонхны системийн байдал зэрэг болно.

Энэ гурван компонент хоорондоо зөрчилдвөл үндэсний эдийн засгийг дэлхийн тавцангаас шахагдаж улмаар улс орноо дэлхийн хөгжлийн гадна үлдэхэд хүргэнэ. Орчин үеийн нэг онцлог бол үндэсний эдийн засагт геоэдийн засгийн нөхцөл, тэргүүлэх чиглэл, үндэсний стратегийн сонирхлын дагуу шинэ үндэсний эдийн засгийн популяцад орж дагаж хувьсаж интернационалжсан үндэсний эдийн засгийн өвөрмөц систем болон хувирч байх юм. Өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засгийн газрын зураг дээр улс-систем гэсэн бүтэц зурагдах боллоо. Улс-систем буюу дэлхийн үйлдвэрлэлийн сүлжээнд нэгж салбар, охин компаниар дамжин үндэсний эдийн засгаа дэлхийн үйлдвэрлэлийн төрөл бүрийн салбар хэсгүүдэд нэгдэж орох үйл явц явагдаж байна. Үүнийг хэрэгжүүлэхдээ үндэсний эдийн засгийг гадаад эдийн засгийн харилцааны макрозагвар болон геоэдийн засгийн (нөхөн үйлдвэрлэлийн) загварын дагуу түүгээр дамжуулан гүйцэтгэнэ. Энэхүү загварын бүтэц нь гадаад эдийн засгийн аливаа загварын нэгэн адил гурван чухал компонентийг агуулна.

- Геоэдийн засгийн загвар (Эдийн засгийн мөн чанар, зүй тогтлыг илэрхийлэх);
- Геоэдийн засгийн загварын эдийн засгийн мөн чанарыг илэрхийлэгч үндсэн зүй тогтлуудыг агуулна (дэлхийн орлого бүрдүүлэх ба хуваарилахад оролцох);

- Удирдлага, зохион байгуулалт-чиг үүргийн холбогдох хэлбэртэй байх, (геоэдийн засгийн зохион байгуулалтын пирамидыг бүрдүүлэх) үндэснийхээ эдийн засгийг геоэдийн засгийн орон зайд хэрхэн дасан зохицох, үндэсний эрх ашиг, сонирхол, тэргүүлэх чиглэлийг дэлхийн аж ахуйн нөхцөлтэй уялдуулж хувиргахад бэлтгэх явдал их чухал байна.

Геоэдийн засгийн орон зайн загвар нь иргэншлийн хөгжлийн шинэ хандлага бөгөөд дэлхийн эдийн засгийн орон зайг шинэ өнгө аястай болгож үүгээрээ XXI зууны шинэ төрхийг тодорхойлж байна. Геоэдийн засгийн орон зай ингэж тэлэхийн сацуу геополитикийн болон геостратегийн орон зай түүнд захирагдах шинжтэй болж байна. Ийм нөхцөлд гурав дахь хөршийн геополитикийн бодлогыг яаж геоэдийн засгийн бодлоготой хослуулах вэ? Монгол Японы иж бүрэн түншлэлийн харилцаанд геоэдийн засгийн аспектиг яаж давуу байр суурьтай байлгах вэ? Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын геоэдийн засаг, геополитик, геостратегийн ямар секторт нь бид илүү анхаарвал зохих вэ? Европын холбоог Монголын геоэдийн засгийн орон зайд яаж оруулах вэ? Эсвэл Европын геоэдийн засгийн орон зайд Монгол яаж орох вэ? Орос, Хятад улсуудын геоэдийн засгийн орон зайгаар дамжиж дэлхийн орлогын үйлдвэрлэл хуваарилалтад орох боломж бий юу? Монгол улсын цөмийн зэвсэггүй статус үндэсний аюулгүй байдлын баталгаа мөн үү? Үүнийг эрх зүйн баталгаатай болгохын тулд юу хийх ёстой вэ? Их гүрнүүдийн Монгол дахь стратегийн сонирхол юунд байна вэ? Энэ сонирхлыг геоэдийн засгийн орон зай руу түлхүү хандуулах боломж бий юу? гэхчлэн Монгол улсын геоэдийн засгийн үй түмэн асуудал байх шиг байна. Хүйтэн дайны төгсгөлтэй уялдаж геополитикийн болон геостратегийн орон зайн дэлхийн бодлогод үзүүлэх нөлөө харьцангуй багасах учиртай гэж ярьж бичиж байх бололтой. Эдийн засгийн хөгжлийн загварын хувьд аж үйлдвэржүүлэх загвараас татгалзаж геоэдийн засгийн буюу нөхөн үйлдвэрлэлийн шинэ эдийн засгийн загварт шилжиж байна. Ийм нөхцөлд Монголын гадаад эдийн засгийн харилцааны загвар дэлхийн гадаад эдийн засгийн макро загвартай яаж холбогдох ёстой вэ? гэх мэтчилэн олон асуудалд зөв хариу олж үйл ажиллагаагаа түүнд чиглүүлэхэд Монголын гадаад эдийн засгийн харилцааны номлол, загварын мөн чанар орших ёстой байна.

Дүгнэлт:

1. Улс орон бүр өөрийнхөө үндэсний эдийн засгийг гадаад ертөнцтэй харилцах систем бүрдүүлж, геоэдийн засгийн орон зайд өөрийнхөө үүрэг, байр суурийг тодорхойлж, стратегийн зорилт, үндэсний эрх ашиг, тэргүүлэх чиглэлээ тунхаглаж байна.
2. Үндэснийхээ эдийн засгийн сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд улс орон бүр гадаад эдийн засгийн орчинтой харилцах нөхцлийг хангах өөрийн эдийн засгийн гол шинжүүдийг илэрхийлсэн гадаад эдийн засгийн загварыг боловсруулдаг бөгөөд тэр нь үндэсний эдийн засгийг гадаад ертөнцтэй холбох гүүр болдог байна.
3. Бүтцийн хувьд гадаад эдийн засгийн загвар нь гурван чухал компонентийг агуулдаг байна. *Нэгд* загварын эдийн засгийн мөн чанарыг илэрхийлэх үндсэн зүй тогтлууд, *хоёрт* удирдлагын болон зохион байгуулалт, чиг үүргийн хэлбэр, *гуравт* шийдвэр гаргах арга зүйн алба.
4. Гадаад эдийн засгийн харилцаанд худалдааны, хангамж борлуулалтын, нөхөн үйлдвэрлэлийн гэсэн гурван үндсэн загвар байна.
5. Гадаад эдийн засгийн хамгийн дэвшилттэй загвар нь геоэдийн засгийн орон зайд стратегийн үр ашгийг олох, дэлхийн орлогыг бүрдүүлэх ба хуваарилахад оролцох боломжоор хангах чадвартай нөхөн үйлдвэрлэлийн (үйлдвэрлэл-хөрөнгө оруулалтын) загвар юм.
6. ГЭЗХ-ны нөхөн үйлдвэрлэлийн загвар нь хөгжилтэй орнуудыг дэлхийн эдийн засгийн лидер болгосон байна. Энэ загварын тусламжтайгаар улс орон “улс-систем”-ийн эгнээнд дэлхийн хэмжээний үйлдвэрлэгч, эзний зиндаагаар оролцох болно. Онолын хувьд энэ загварыг ашиглах боломжгүй улс орон гэж байх учиргүй.
7. Их гүрнүүдийн стратегийн сонирхлыг олж тодорхойлох нь Монгол улсын гадаад эдийн засгийн бодлогын дэлхийн геоэдийн засгийн орон зайд байр сууриа олоход их ач холбогдолтой байж болох юм.

Ашигласан эх сурвалж:

1. Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого (төсөл) 2006
2. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2006
3. Шишков, Ю.В. Мировая экономика: Наростающий процесс глобализации.(прогноз на 2000-2015 годы) М. 1998
4. Астопович, А.З. Транснациональный капитал США в мировом хозяйстве. М. 1990
5. Баковецкий, О.Д., Шейкин Э.Я. Отгруппировок к общей Европе. М. 1992
6. Кочетов Э.Г. Геоэкономика. М.1999
7. Борох О.Н. Современная китайская экономическая мысль. М. 1998
8. Пол Кенеди. Вступая в двадцать первый век. М. 1997
9. Прыкин Б.В. Новейшая теоритическая экономика. М.1998